



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/300

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны “Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XIV/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дэлхийн “Алтаргана 2024” Олон улсын 15 дугаар их наадамд хэрэглэгдэх нэгдсэн парад хувцас хийлгэх ажлыг Боловсрол шинжлэх ухааны газрын дүрслэх урлаг, дизайн технологи, шинжлэх ухаан инновац, мэргэжлийн боловсролын сургалт хариуцсан мэргэжилтэн (Ж.Орхонтуул)-д даалгасугай.

2.Парад хувцсанд шаардагдах 5,020,000 (таван сая хорин мянга) төгрөгийг “Алтаргана 2024” наадмыг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

